



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүнс, хөдөө аж ахуйн газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/36/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Эрдэнэт хот
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 99921600 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3. Аудитын тайлан	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХАА	Хөдөө аж ахуй

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.01.25 № 22
танай _____-ны № _____-Т

ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН
ГАЗРЫН ДАРГА Ж.БАТ-ӨЛЗИЙ
ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүнс хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	107,000,734.88	148,504,743.90
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,970,000.00	1,754,300.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,970,000.00	1,754,300.00
31210	Төгрөг	2,970,000.00	1,754,300.00
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк дахь харилцах (НД)	2,970,000.00	1,754,300.00
34	УРЬДЧИЛГАА	0.00	7,200,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	0.00	7,200,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	104,030,734.88	139,550,443.90
35100	Түүхий эд материал	33,866,699.88	33,598,979.88
35110	Тусгай зориулалттай материал	33,866,699.88	33,598,979.88
35400	Хангамжийн материал	70,164,035.00	105,951,464.02
35410	Бичиг хэргийн материал	1,508,165.00	166,720.00
35420	Аж ахуйн материал	568,186.00	2,309,060.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,000,000.00	2,550,000.00
35440	Түлш, шатах тослох материал	310,000.00	420,000.00
35470	Бусад хангамжийн материал	65,777,684.00	100,505,684.02
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	361,803,023.64	82,812,761.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	361,803,023.64	82,812,761.00
39200	Биет хөрөнгө	95,770,023.72	76,025,761.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	61,364,496.87	61,364,496.87
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(7,530,946.32)	(12,255,741.48)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	112,748,772.52	112,748,772.52
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(93,440,438.94)	(102,073,772.22)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	40,660,509.43	35,225,197.23
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(29,139,740.43)	(28,198,086.73)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,392,330.16	23,596,963.16
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(18,284,959.57)	(14,382,068.19)
39300	Биет бус хөрөнгө	266,032,999.92	6,786,999.84
39301	Программ хангамж	5,257,500.00	4,300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Программ хангамж	(2,332,500.08)	(2,375,000.16)
39303	Бусад биет бус хөрөнгө	263,108,000.00	4,862,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	468,803,758.52	231,317,504.90
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	468,803,758.52	231,317,504.90
51	Засгийн газрын хувь оролцоо	468,803,758.52	231,317,504.90
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	550,935,889.75	292,689,889.75
51200	Хуримтлагдсан үр дүн	(87,456,522.33)	(66,696,775.95)
51210	Өмнөх үеийн үр дүн	(87,490,754.45)	(87,456,522.33)
51220	Тайлант үеийн үр дүн	34,232.12	20,759,746.38

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,324,391.10	5,324,391.10
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	468,803,758.52	231,317,504.90

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	651,627,551.74	607,205,492.11
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	211,107,918.74	192,219,369.07
1200	Нийтлэг татварын бус орлого	211,107,918.74	192,219,369.07
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	977,500.00	366,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	977,500.00	366,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	3,003,000.00	0.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	207,127,418.74	191,853,369.07
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	440,519,633.00	414,986,123.04
1310	Улсын төсвөөс	357,559,800.00	313,713,423.04
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	357,559,800.00	313,713,423.04
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	82,959,833.00	101,272,700.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид	80,800,733.00	101,272,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,159,100.00	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	651,593,319.62	430,019,976.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	651,593,319.62	430,019,976.68
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	598,092,076.53	411,900,376.68
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	152,488,198.95	205,177,456.88
210101	Үндсэн цалин	111,984,399.80	152,012,214.47
210102	Нэмэгдэл	36,004,499.15	40,459,241.13
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	4,499,300.00	12,706,001.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,501,600.00	26,284,884.23
210201	Тэтгэврийн даатгал	19,730,100.00	18,416,156.94
210202	Тэтгэмжийн даатгал	1,442,900.00	2,051,068.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,154,300.00	1,640,855.01
210204	Ажилгүйдлийн даатгал	288,500.00	379,709.57
210205	Эрүүл мэндийн даатгал	2,885,800.00	3,797,094.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,446,762.63	18,978,655.93
210301	Гэрэл, цахилгаан	802,743.42	882,434.72
210302	Түлш, халаалт	2,274,764.21	1,827,310.08
210303	Цэвэр, бохир ус	992,039.00	2,491,695.13
210304	Байрны түрээс	13,377,216.00	13,777,216.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,402,483.54	50,180,507.00
210401	Бичиг хэрэг	3,332,470.00	20,356,095.00
210402	Тээвэр, шатахуун	19,169,600.00	21,668,200.00

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,317,299.50	1,186,736.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	595,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,701,932.00	6,374,476.00
210408	Бараа материал акталсны зардал	17,881,182.04	0.00
2105	Нормативт зардал	40,735,200.00	44,518,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	33,400,000.00	41,992,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,335,200.00	2,526,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,981,900.00	2,570,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	126,400.00	0.00
210604	Урсгал засвар	2,855,500.00	2,570,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,210,300.00	2,334,200.00
210702	Дотоод албан томиллолт	5,210,300.00	2,334,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	288,953,019.57	33,309,590.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	285,783,449.57	28,316,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	864,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	201,960.00	201,960.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	265,720.00	210,470.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	3,600,000.00
210807	Газрын төлбөр	1,360,890.00	39,660.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,372,611.84	28,547,082.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	7,238,520.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	21,372,611.84	21,308,562.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,501,243.09	18,119,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,267,286.00	18,119,600.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	43,178,286.00	7,283,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,089,000.00	10,835,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,059,957.09	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,058,857.09	0.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,100.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	174,000.00	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	174,000.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	34,232.12	177,185,515.43
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	156,425,769.05
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	0.00	156,425,769.05
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал зардал - бараа материал	0.00	156,425,769.05
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	34,232.12	20,759,746.38

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	550,935,889.75	4,344,369.30	(87,456,522.33)	467,823,736.72
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	550,935,889.75	4,344,369.30	(87,456,522.33)	467,823,736.72
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт		980,021.80		980,021.80
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз				
7	Өмчид гарсан өөрчлөлт				
8	Зарласан ноогдол ашиг				
9	Тайлант үеийн үр дүн				
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	550,935,889.75	5,324,391.10	(87,456,522.33)	468,803,758.52
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	550,935,889.75	5,324,391.10	(87,456,522.33)	468,803,758.52
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	550,935,889.75	5,324,391.10	(87,456,522.33)	468,803,758.52
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(258,246,000.00)			(258,246,000.00)
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз				
17	Өмчид гарсан өөрчлөлт				
18	Зарласан ноогдол ашиг				
19	Тайлант үеийн үр дүн			20,759,746.38	20,759,746.38
20	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	292,689,889.75	5,324,391.10	(66,696,775.95)	231,317,504.90

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	441,742,118.00	415,888,056.04

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	977,500.00	366,000.00
1200	Нийтлэг татварын бус орлого	977,500.00	366,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	977,500.00	366,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	977,500.00	366,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	440,764,618.00	415,522,056.04
1310	Улсын төсвөөс	357,559,800.00	313,713,423.04
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	357,559,800.00	313,713,423.04
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	82,959,833.00	101,272,700.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	80,800,733.00	101,272,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,159,100.00	
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	244,985.00	535,933.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	244,985.00	535,933.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	439,772,218.00	416,539,456.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	439,772,218.00	416,539,456.04
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	386,025,989.91	397,757,923.04
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	152,488,198.95	205,177,456.88
210101	Үндсэн цалин	111,984,399.80	151,972,183.74
210102	Нэмэгдэл	36,004,499.15	40,499,271.86
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	4,499,300.00	12,706,001.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,501,600.00	26,284,884.23
210201	Тэтгэврийн даатгал	19,730,100.00	18,416,156.94
210202	Тэтгэмжийн даатгал	1,442,900.00	2,051,068.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,154,300.00	1,640,855.01
210204	Ажилгүйдлийн даатгал	288,500.00	379,709.57
210205	Эрүүл мэндийн даатгал	2,885,800.00	3,797,094.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,446,762.63	19,258,655.93
210301	Гэрэл, цахилгаан	802,743.42	1,162,434.72
210302	Түлш, халаалт	2,274,764.21	1,827,310.08
210303	Цэвэр, бохир ус	992,039.00	2,491,695.13
210304	Байрны түрээс	13,377,216.00	13,777,216.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,036,748.50	41,909,286.00
210401	Бичиг хэрэг	2,662,500.00	19,496,650.00
210402	Тээвэр, шатахуун	17,954,600.00	17,748,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,407,299.50	1,186,736.00

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		595,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,012,349.00	2,882,700.00
2105	Нормативт зардал	40,928,200.00	46,023,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	33,400,000.00	40,296,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,528,200.00	5,727,000.00
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,211,900.00	8,051,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	356,400.00	772,000.00
210604	Урсгал засвар	2,855,500.00	7,279,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,210,300.00	2,334,200.00
210702	Дотоод албан томилолт	5,210,300.00	2,334,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	116,202,279.83	47,839,590.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	113,032,709.83	35,646,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	864,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	201,960.00	201,960.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	265,720.00	210,470.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	10,800,000.00
210807	Газрын төлбөр	1,360,890.00	39,660.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		879,850.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		879,850.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,746,228.09	18,781,533.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,512,271.00	18,781,533.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	244,985.00	535,933.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	43,178,286.00	7,283,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,089,000.00	10,961,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,059,957.09	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,058,857.09	
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,100.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	174,000.00	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	174,000.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	1,969,900.00	(651,400.00)
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,799,900.00	564,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,799,900.00	564,300.00
222	ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ		564,300.00
222001	Тоног төхөөрөмж		564,300.00

223	БУСАД ХӨРӨНГӨ	2,799,900.00	
223004	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,799,900.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	(2,799,900.00)	(564,300.00)
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	(830,000.00)	(1,215,700.00)
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,800,000.00	2,970,000.00
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,970,000.00	1,754,300.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
70801	Мал аж ахуйг хөгжүүлэх	6,900,000.00	6,900,000.00
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	600,000.00	600,000.00
12	Татварын бус орлого	600,000.00	600,000.00
12200	Тусламжийн орлого	600,000.00	600,000.00
122005	Төсвөөс санхүүжих	600,000.00	600,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	600,000.00	600,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	600,000.00	600,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	600,000.00	600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	600,000.00	600,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	600,000.00	600,000.00
80102	Туслах үйл ажиллагааны зардал		
82511	Цөм сүргийн үржлийн ажил үйлчилгээ		
82542	Монгол мал хөтөлбөр	6,300,000.00	6,300,000.00
12	Татварын бус орлого	6,300,000.00	6,300,000.00
12200	Тусламжийн орлого	6,300,000.00	6,300,000.00
122005	Төсвөөс санхүүжих	6,300,000.00	6,300,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,300,000.00	6,300,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,300,000.00	6,300,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,300,000.00	6,300,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнийн төлбөр, хураамж	6,300,000.00	6,300,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,300,000.00	6,300,000.00
70802	Газар тариалан хөгжүүлэх	5,000,000.00	5,000,000.00
82528	Ургацын комисс, төв штаб, удирдлагын зардал	5,000,000.00	5,000,000.00
12	Татварын бус орлого	5,000,000.00	5,000,000.00
12200	Тусламжийн орлого	5,000,000.00	5,000,000.00
122005	Төсвөөс санхүүжих	5,000,000.00	5,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,000,000.00	5,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,000,000.00	5,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,000,000.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнийн төлбөр, хураамж	5,000,000.00	5,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00	5,000,000.00
70805	Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого удирдлага	301,968,000.00	298,369,423.04
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	293,938,100.00	290,339,523.04
12	Татварын бус орлого	293,938,100.00	290,339,523.04
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
12000	Нийтлэг татварын бус орлого		366,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/		366,000.00
12200	Тусламжийн орлого	293,938,100.00	289,973,523.04
122005	Төсвөөс санхүүжих	293,938,100.00	289,973,523.04
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	293,938,100.00	290,339,523.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	293,938,100.00	289,775,223.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	293,938,100.00	289,775,223.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	206,482,900.00	205,177,456.88
210101	Үндсэн цалин	154,172,600.00	151,972,183.74
210102	Нэмэгдэл	47,961,100.00	40,499,271.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,349,200.00	12,706,001.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,404,100.00	26,284,884.23
210201	Тэтгэврийн даатгал	19,395,400.00	18,416,156.94
210202	Тэтгэмжийн даатгал	2,002,200.00	2,051,068.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,601,700.00	1,640,855.01
210204	Ажилгүйдлийн даатгал	400,500.00	379,709.57
210205	Эрүүл мэндийн даатгал	4,004,300.00	3,797,094.14

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,658,800.00	18,768,655.93
210301	Гэрэл, цахилгаан	714,400.00	672,434.72
210302	Түлш, халаалт	2,615,900.00	1,827,310.08
210303	Цэвэр, бохир ус	2,551,300.00	2,491,695.13
210304	Байрны түрээс	13,777,200.00	13,777,216.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,685,000.00	9,684,086.00
210401	Бичиг хэрэг	1,811,900.00	1,860,650.00
210402	Тээвэр, шатахуун	5,464,000.00	5,464,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,183,300.00	1,186,736.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	53,100.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,172,700.00	1,172,700.00
2105	Нормативт зардал	2,387,000.00	2,387,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	300,000.00	300,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,087,000.00	2,087,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,615,300.00	8,051,000.00
210601	Багаж, техник хэрэгсэл	1,336,300.00	772,000.00
210604	Урсгал засвар	7,279,000.00	7,279,000.00
2107	Томилолт, зочны зардал	894,200.00	894,200.00
210702	Дотоод албан томилолт	894,200.00	894,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	17,930,900.00	17,648,090.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,455,000.00	5,455,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	864,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	202,000.00	201,960.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	319,100.00	210,470.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	154,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,800,000.00	10,800,000.00
210807	Газрын төлбөр	136,800.00	39,660.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	879,900.00	879,850.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	879,900.00	879,850.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		564,300.00
222001	Тоног төхөөрөмж		564,300.00
80102	Туслах үйл ажиллагааны зардал		
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	8,029,900.00	8,029,900.00
12	Татварын бус орлого	8,029,900.00	8,029,900.00
12200	Тусламжийн орлого	8,029,900.00	8,029,900.00
122005	Төсвөөс санхүүжих	8,029,900.00	8,029,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,029,900.00	8,029,900.00

21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,029,900.00	8,029,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,029,900.00	8,029,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,283,900.00	7,283,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	746,000.00	746,000.00
72101	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх ажлын байр олгох	3,810,000.00	3,810,000.00
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	3,810,000.00	3,810,000.00
12	Татварын бус орлого	3,810,000.00	3,810,000.00
12200	Тусламжийн орлого	3,810,000.00	3,810,000.00
122005	Төсвөөс санхүүжих	3,810,000.00	3,810,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,810,000.00	3,810,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,810,000.00	3,810,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,810,000.00	3,810,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	3,810,000.00	3,810,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,810,000.00	3,810,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)	101,272,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	101,272,700.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	92,272,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	490,000.00
210301	Гэрэл, цахилгаан	490,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,225,200.00
210401	Бичиг хэрэг	17,636,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,284,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	595,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,710,000.00
2105	Нормативт зардал	43,636,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	39,996,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,640,000.00
2107	Томилот, зочны зардал	1,440,000.00
210702	Дотоод албан томилот	1,440,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,481,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,481,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)	101,272,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	101,272,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	101,272,700.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	101,272,700.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бейкер Тилли Далайван аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, эхний шатны хяналтыг ахлах аудитор Д.Мягмарсүрэн хэрэгжүүлж, 2 болон 3-р шатны хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, Орхон аймгийн Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүнс, хөдөө аж ахуйн газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарын талаар баримтлах бодлогыг аймгийн хэмжээнд мэргэжлийн үндсэн дээр чанартай зохион байгуулж, хэрэгжүүлэн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж, эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, хөнгөн болон жижиг, дунд

үйлдвэр, хоршоо ахуйн үйлчилгээний салбарыг дэмжин, хүн амын хүнсний хангамжийг тогтвортой байлгах зорилгоор үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант оны үйл ажиллагааны чиглэл:

- Хүнсний үйлдвэрлэлд шинэ технологи нэвтрүүлж, бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах
- Мал сүргийн чанарыг сайжруулж, байгалийн эрсдэлээс сэргийлэх, эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх
- Газар тариаланд дэвшилттэй техник, технологи нэвтрүүлж, га-ын ургацын хэмжээг нэмэгдүүлэх
- Жижиг, дунд, хөнгөн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх
- Хоршоо, ахуй үйлчилгээ эрхлэгчдийг бодлогоор дэмжих

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүнс, хөдөө аж ахуйн газар 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 317,678.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,176.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,223.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 237,486.3 мянган төгрөгөөр буюу 49,3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,970.0	1,754.3	(1,215.7)
Авлага	0	7,200.0	7,200.0
Бараа материал	104,030.7	139,550.4	35,519.7
Үндсэн хөрөнгө	361,803.0	82,812.8	(278,990.2)
Нийт хөрөнгө	468,803.8	231,317.5	(237,486.3)
Өр төлбөр	0.0	0.0	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	468,803.8	231,317.5	(237,486.3)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	468,803.8	231,317.5	(237,486.3)

Бараа материалын данс 139,550.4 мянган төгрөг болж 35,519.7 мянган төгрөгөөр өссөн нь өрхийн тариалан эрхлэлтийг дэмжих сангаас олгох хүлэмж, өвс тэжээл, тээвэр шатахуун, бичиг хэргийн зардлаас худалдан авсан бичиг хэргийн материал болон тусгай зориулалтын материал нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Мөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2021 оны 02 дугаар сарын 15-ны 219 дүгээр тогтоолоор нийт 12,752.4 мянган төгрөгийн 17 нэр төрлийн тоног төхөөрөмж тавилга, аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 13-ны А/660 дугаар захирамжийн дагуу 258,246.0 сая төгрөгийн аграг паркийн газар, лаборторын газар нийт 270,998.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хассан.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 44,422.1 мянган төгрөгөөр буюу 6.8 хувиар, нийт зардал өмнөх оноос 221,573.3 мянган төгрөгөөр буюу 6.5 хувиар тус тус буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хүнс, хөдөө аж ахуйн газар 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 543,352.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 543,352.3 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 257,451.8 мянган төгрөгөөр бууруулан улсын төсвийг 285,900.5 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төсвийг 3 удаа тодотгол хийж 27,812.9 мянган төгрөгөөр нэмж 313,713.4 мянган төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр 313,713.4 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжиж, орон нутгаас 101,272.7 мянган төгрөг урсгал үйл ажиллагаанд 414,986.1 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт буцаан мөнгө төвлөрүүлээгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Засаг даргын захирамжаар, орон нутгийн төсвөөс арван таван төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр 101,272.7 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үед Засгийн газрын 43-р тогтоолын дагуу тусгай чиг үүргээс бусад төсөвт байгууллагуудыг төсвийн хэмнэлт хийх талаар чиглэл үүрэг болгосон ба тус чиг үүргийг хангалтгүй биелүүлсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2021 онд нийт 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй, 147 мэдээллийг ил тод байршуулж, хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2021 онд шилэн дансанд 8 сард ковидтой холбоотой мэдээлэл, батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл зэргийг хугацаа хоцроож байршуулсан байна. Мөн шилэн дансанд мэдээлэх мэдээллийн талаар талбар бүрээр зөвлөгөө өглөө.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 6,500.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 300.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт	-	-	-	-	-	-	
Албан шаардлага	2	6,500.0	2	6,500.0	-	-	
Зөвлөмж	2	300.0	2	300.0	-	-	
Нийт дүн	4	6,800,0	4	6,800,0	-	-	

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал, урсгал засварын зардлын төлөвлөлт, гүйцэтгэл анхаарал татахаар бөгөөд бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 8,598.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 959.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 169.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт, 7,470.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитад залруулсан алдаа байхгүй.

4.2 Албан шаардлага

Орхон аймгийн засаг даргын А/101 дүгээр захирамжаар аймаг сумын аюулгүйн нөөцөд бэлтгэсэн өвс тэжээлийг олгохдоо журмын дагуу малын тоонд үндэслэсэн бичиг баримт байхгүй цохолт зөвшөөрөлгүй олгосон байна. Энэ нь Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын 2021 оны 02 сарын 23-ны өдрийн А/06 дугаар тушаалаар батлагдсан "Малчин, мал бүхий өрхөд 2021 онд аймаг, сумын аюулгүйн нөөцөд бэлтгэсэн өвс, тэжээлийг малчдад олгох, хяналт тавих журам" 3.2 -т заасны дагуу жилийн эцэст тоологдсон А дансанд үндэслэн малын тоо толгойгоор тооцоо гаргаж олгох, 3.9 -т заасан бичиг баримтын дагуу олгож байх гэсэн заалтыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлэв.

Холбогдох хууль тогтоомжийг баримтлан гаргасан тушаал, журмыг баримтлан үндэслэх баримт бичгийг бүрэн бүрдүүлж байх.

4.3 Акт

Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу е баримтгүй 169.0 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчсөнд акт хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Мэдээлэл технологи үйлчилгээний зардалд 10 800.0 мянган төгрөг төсөвлөн 3 600.0 мянган төгрөг төлсөн боловч 7 200.0 мянган төгрөгийг урьдчилж төлсөн тооцоогоор бүртгэн харилцагч байгууллага руу шилжүүлсэн байна. Энэ “Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийг бодитой үнэн зөв төсөвлөж, хэмнэлттэй зарцуулах,

2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Хувь хүнээс ажил үйлчилгээ авсны хөлс 270.0 мянган төгрөгөөс НДШ тооцоогүй байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32.2 Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээгээр тохирсон хөлс; гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэгчийн нийгмийн даатгалын шимтгэлийг тооцож тайлагнах.

3. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Шилэн дансанд 8 сард ковидтой холбоотой мэдээлэл, батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл зэргийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх; 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

Хугацаанд нь үнэн зөв, бүрэн мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хүнс, хөдөө аж ахуйн газар	5	8,598.9			1	169.0	1	959.9	3	7,470.0
	Дүн	5	8,598.9			1	169.0	1	959.9	3	7,470.0

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:

"БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ" ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР:



Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР, ЗАХИРАЛ:



Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР:



Б.ЭРДЭНЭ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Ц.НАРМАНДАХ